

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны ... дугаар
сарын-ний өдөр

Дугаар....

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан "Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал"-ын 4.5 дугаар зүйл, "Замын-Үүдийн дулааны станц" ТӨҮГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 1/232 дугаар албан бичгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг "Замын-Үүдийн дулааны станц" ТӨҮГ (О.Төмөрхуяг)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны "Тариф батлах тухай" 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 219, 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 732, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 178 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ний өдрийн
.... дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт байгууллага	Эзлэхүүнээр халаалт	Төг/м³	3,210.0	
		Хэмжүүрээр халаалт	хувьсах	Төг/ГЖ	27,642.0
			тогтмол	Төг/м³	1,063.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м³	4,000.0	
			Төг/хүн	5,000.0	

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны ... дугаар сарын ...-ний өдрийн
... дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН ҮЙЛДВЭР,
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА БОЛОН АЙЛ ӨРХӨД
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал			Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага	Эзлэхүүнээр халаалт		Төг/м³	2,000.0
		Хэмжүүрээр халаалт	хувьсах	Төг/ГЖ	24,570.0
			тогтмол	Төг/м³	945.0
		Хэрэгцээний халуун ус халаасан дулаан		Төг/м³	4,000.0
				Төг/хүн	5,000.0
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “00” –ын өрөөний халаалт хамаарна)			Төг/м²	1,400.0
3	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан			Төг/м³	4,000.0
4	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф	40 м² хүртэлх талбайтай айл өрх		Төг/сар	3,000.0
		41 м²- 80 м² талбайтай айл өрх		Төг/сар	5,000.0
		81 м²-аас дээш талбайтай айл өрх		Төг/сар	10,000.0